

# Өвчний Хяналтын Төвийн (C.D.C) Албадан Нүүлгэлтийг Түр Хойшуулах Тухай Мэдээллийн Хуудас

Өвчний Хяналтын Төвөөс (C.D.C) 2021 оны 8-р сарын 3-нд COVID-19-ийн тархалтаас сэргийлэхэд туслах зорилгоор АНУ дахь олон түрээслэгчдэд зориулан албадан нүүлгэлтийг түр хойшуулах тухай үндэсний хэмжээний шинэ тушаалыг гаргасан байна. Уг тушаал нь COVID-19-ийн тархалтын түвшин нилээд их эсвэл өндөр үзүүлэлттэй байгаа АНУ-ын мужуудад амьдардаг түрээслэгчдэд зориулан 2021 оны 8-р сарын 3-наас 2021 оны 10-р сарын 3 хүртэл хүчин төгөлдөр байна. CDC-ийн 7-р сарын 31-нд дууссан өмнөх түр хойшуулах тушаалын дагуу мэдүүлэг гаргасан түрээслэгчид дахин мэдүүлэг гаргах шаардлагагүй. Уг тушаал нь мужийн эсвэл орон нутгийн илүү хүчтэй албадан нүүлгэлтийн хамгаалалтыг орлохгүй эсвэл хүчингүй болгохгүй ба түрээслэгч, дэмжигчид орон нутгийн, мужийн болон холбооны илүү хүчтэй хамгаалалтыг авахын төлөө тэмцлээ үргэлжлүүлэх нь зүйтэй. **Конгрессоос мужуудад түрээс ба орон сууцны ашиглалтын зардалд 40 гаруй тэрбум ам.долларын туслалцаа үзүүлжээ. Өөрийн хэсэгтээ хэрхэн өргөдөл гаргах талаар мэдэхийн тулд <https://bit.ly/CFPBERAP> руу очно уу.**

## Таны мэдэх хэрэгцээтэй зүйлс

- Уг тушаал нь COVID-19-ийн тархалтын түвшин нилээд их эсвэл өндөр үзүүлэлттэй байгаа мужуудад нэг гэр бүлийн сууц, зөврийн сууц болон орон сууц зэрэг түрээсийн бүх үл хөдлөх хөрөнгийг үндсэндээ хамардаг. Түрээслэгчид ба түрээслүүлэгчид хамрагдсан хэсэгт оршин сууж буй эсэхээ <https://covid.cdc.gov/covid-data-tracker/#county-view> дээрээс шалгах боломжтой.
- Хэрэв түрээслэгчид түрээслүүлэгчдээ CDC-ийн мэдүүлгийг (доорх мэдүүлгийг хар) өгсөн бол уг тушаалаар түрээслүүлэгчдийг болзол хангасан хэсэгт оршин сууж буй түрээслэгчдийг түрээс төлөөгүйн улмаас албадан нүүлгэхийг 2021 оны 10-р сарын 3 хүртэл хориглоно.
- Түрээслэгч нь түрээслүүлэгчдээ нэгэнт мэдүүлэг илгээсэн бол түрээслүүлэгч нь 2021 оны 10-р сарын 3-наас өмнө тухайн түрээслэгчийг түрээс төлөөгүйн улмаас байрнаас гаргах эсвэл гаргахад хүргэх ямар нэг үйлдэл хийх ёсгүй — үүнд, түрээслэгчийг шүүхийн нэхэмжлэлээр дамжуулан албадан нүүлгэх эсвэл байраа суллахыг шаардан дарамтлах эсвэл заналхийлэх зэрэг үйлдлүүд багтана.
- Энэ нь төлөх ёстой байгаа түрээсийн төлбөрийг цуцлахгүй эсвэл зогсоохгүй эсвэл тушаалын хугацаа дууссаны дараа төлөх ёстой болох түрээсийн хуримтлагдсан төлбөрийг ЗОГСООХГҮЙ.
- Уг тушаал нь болзол хангасан түрээслэгчдийг түрээс төлөөгүйгээс бусад зарим нэг шалтгаанаар албадан нүүлгэхийг зөвшөөрдөг (мужийн эсвэл орон нутгийн хуулиар “үндэслэлтэй шалтгаанаар” илүү хүчтэй хамгаалалтаар хангахаас бусад тохиолдолд): Тухайн байранд байхдаа гэмт хэрэгт холбогдох; оршин суугчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд заналхийлэх; өмч хөрөнгөд хохирол учруулахаар шууд болон ноцтой эрсдэлд оруулах; холбогдох барилга байгууламжийн дүрэм журам, эрүүл мэндийн тогтоол, эсвэл эрүүл мэнд болон аюулгүй байдалтай холбоотой дүрэм журмыг зөрчих, түрээсийн төлбөрийг цаг тухайд нь төлөх эсвэл орон сууцтай холбоотой төлбөрийг (төлбөр, торгууль, хүүний хугацаа хэтрүүлэх, эсвэл төлөхгүй байх зэрэг багтсан) төлөхөөс бусад дүрэм журмыг зөрчих.

## Би шаардлага хангаж байна уу?

Түрээслэгчид дараах тохиолдолд хамгаалалтын шаардлага хангана:

- CDC-ээс тархалтын түвшин нилээд их эсвэл өндөр үзүүлэлттэй гэж тодорхойлсон мужид амьдрах: <https://covid.cdc.gov/covid-data-tracker/#county-view>
- эрүүл мэндийн зардал, эсвэл орлогогүй болсны улмаас түрээсээ төлөх боломжгүй
- 2021 онд хувь хүн дангаараа \$99,000, эсвэл гэр бүлээрээ \$198,000-аас бага орлого олно гэж тооцоолж байгаа, эсвэл урамшуулалын тэтгэмжийн чек авсан, эсвэл 2020 оны татварын тайлан гаргах шаардлагагүй байсан
- засгийн газрын боломжит түрээсийг дэмжих сангаас тусламж авахаар мэдүүлэг өгсөн эсвэл мэдүүлэг өгч байгаа
- хэрэв боломжтой бол төлж чадах төлбөрийн хэмжээнд тохируулан түрээсийг хэсэгчлэн төлөх үүрэгтэйгээ ойлгож байгаа
- хэрэв түрээслэгчдийг албадан нүүлгэвэл орон гэргүй болох, эсвэл хүн амын хөл хөдөлгөөн ихтэй, шаардлага хангахгүй нөхцөлд шилжин суурьших нөхцөл байдалтай байгаа.

Дээрх хамгаалалтыг авахын тулд түрээслэгчид — тухайн гэр бүлд амьдарч буй насанд хүрсэн бүх хүмүүс — өөрийн түрээслүүлэгчиддээ хуулийн дагуу үнэн байдлаа мэдүүлж, эрх зүйн хувьд хамгаалалтанд орох шаардлага хангаж байгаа гэдгийг мэдэгдэж, гарын үсэг зурсан мэдүүлгийг (доороос харна уу) өгөх ёстой. Түрээслэгч нь түрээслүүлэгчтэй холбогдох бүх захидал харилцаа болон мэдүүлгийн хуулбарыг хадгалах ёстой.

Хэрэв таныг албадан нүүлгэх гэж байгаа эсвэл мэдүүлгийн талаар хууль эрх зүйн тусламж хэрэгтэй байгаа бол орон нутгийн хууль эрх зүйн үйлчилгээний байгууллага буюу эсвэл орон нутгийн олон нийтийн зохион байгуулалтын бүлэгтэй холбогдоно уу.

PolicyLink

nhlp NATIONAL HOUSING LAW PROJECT

PARTNERSHIP for Working Families

PUBLIC ADVOCATES MAKING RIGHTS REAL

RIGHT TO THE CITY

PEOPLE'S ACTION INSTITUTE

Alliance for Housing Justice

THE CENTER FOR POPULAR DEMOCRACY

MHAction Manufactured Housing Action

PRRAC Poverty & Race Research Action Council

NATIONAL LOW INCOME HOUSING COALITION



## АЛБАДАН НҮҮЛГЭЛТЭЭС ХАМГААЛАХ МЭДҮҮЛЭГ

Өвчин Хянах ба Сэргийлэх Төвүүдээс (CDC) таныг амьдарч буй газраас тань албадан нүүлгэх эсвэл зайлуулахаас хамгаалах тушаалыг гаргасан. Энэ нь та болзол хангасан тохиолдолд амьдарч буй газартаа 2021 оны 10-р сарын 3 хүртэл байрласан хэвээр байх боломжтой гэсэн үг юм.

### Энэ маягыг хэрхэн ашиглах вэ

1. Та CDC-ээс гаргасан тушаалын дагуу албадан нүүлгэлтээс хамгаалагдах шаардлагыг хангаж буй эсэхээ олж мэдээрэй. Хэрэв та мэргэжилтнээс тусламж авахыг хүсвэл (800) 569-4287 дугаарт залгах эсвэл Орон Сууц, Хот Төлөвлөлтийн Хэлтсээс (HUD) зөвшөөрөлтэй орон нутгийн орон сууцны зөвлөгчийн холбоо барих мэдээллийг авахын тулд <https://www.hudexchange.info/programs/housing-counseling/rental- eviction/> хаягаар зочилно уу.
2. Шаардлага хангаж буйгаа мэдэгдэж дараагийн хуудсан дээрх мэдүүлэгт гарын үсэг зурна уу.
3. Та өөрт тань орон сууц түрээслүүлж буй хувь хүн эсвэл компанид (жишээлбэл, барилгын удирдлага, байрны эзэн гэх мэт.) гарын үсэг зурсан мэдүүлгийн хуудсыг өгнө үү. Уг мэдүүлгийн хуулбарыг эсвэл зургийг өөртөө хадгалж, ямар нэг асуудал гарсан тохиолдолд мэргэжилтэндээ эргэж хандана уу.

Хэрэв таны түрээслүүлэгч Өвчний Хяналтын Төвийн (CDC) тушаалыг зөрчвөл тэдэнд торгууль ногдуулах эсвэл шоронд хорих зэрэг эрүүгийн хариуцлага ногдуулж болзошгүй.

## 1. Би шаардлага хангаж байна уу?

Багана бүрт дор хаяж нэг дөрвөлжинг чагталж байгаа бол та шаардлага хангаж байна гэсэн үг.

### Багана А

ба

### Багана Б

- Би 2020 эсвэл 2021 онд урамшууллын тэтгэмжийн чек (Эдийн Засгийн Нөлөөллийн Төлбөр) хүлээн авсан
- Би 2020 онд Татварын Албанд ямар нэг орлого мэдүүлэх шаардлагагүй байсан
- Би дараах тэтгэмжүүдийн аль нэгийг хүлээн авч байгаа
  - Нэмэлт Тэжээлээр Хангах Тусламжийн Хөтөлбөр (SNAP)
  - Тусламж Шаардлагатай Гэр Бүлд Түр Хугацаанд Үзүүлэх Тусламж (TANF)
  - Нэмэлт Хамгаалалтын Орлого (SSI)
  - Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Нэмэлт Хамгаалалтын Орлого (SSDI)
- 2020 эсвэл 2021 онд би хувь хүн дангаараа \$99,000-оос бага эсвэл гэр бүлээрээ \$198,000-оос бага орлого олсон (эсвэл олно гэж тооцоолж байгаа)

Би дараах шалтгаанаар түрээсээ бүхэлд нь эсвэл орон сууцны төлбөрөө бүхэлд нь төлөх боломжгүй байгаа:

- Манай өрхийн орлого их хэмжээгээр буурсан
- Би ажлаасаа халагдсан
- Миний ажлын цаг эсвэл цалин багассан
- Надад өөрөө төлөх ёстой тусгай эмчилгээний зардал гарсан<sup>1</sup>

Дээрхүүдийн аль нь ч хамаарахгүй — **Та шаардлага хангахгүй.**

Дээрхүүдийн аль нь ч хамаарахгүй — **Та шаардлага хангахгүй.**

**Та багана бүрийн дор хаяж нэг зүйлийг шалгасан уу? Таны орлогын зэрэглэл тохирч байна.**

[Дараагийн хуудсын эхний дөрвөлжинг шалга]

<sup>1</sup> Миний жилийн тохируулсан бохир орлогын 7.5% эсвэл түүнээс ихээр тодорхойлсон

## 2. Шаардлага хангаж байгаа миний мэдүүлэг

Доорх дөрвөлжинг дугуйлсанаар би мэдэгдэл бүрийг үнэн болохыг мэдэгдэж байна.

- Миний орлогын түвшин дээр тайлбарласан нөхцөл шалтгааныг хангаж байна
- Би SARS-CoV-2-ын олон нийтийн дундах тархалтын түвшин нилээд их эсвэл өндөр<sup>2</sup> үзүүлэлттэй АНУ-ын мужид амьдардаг.
- Би бүрэн төлөлтөнд аль болох дөхөж очих хэмжээний хэсэгчилсэн төлөлтийг цаг тухайд нь хийж, түрээс эсвэл орон сууцны төлбөрөө төлөхөд засгийн газраас тусламж авахын тулд бүх чадлаараа хичээсэн.<sup>3</sup>
- Хэрэв намайг албадан нүүлгэсэн бол надад амьдрах өөр орон сууцны сонголт байхгүй тул би дараах байдалд хүрэх байсан:
  - Орон гэргүй болох **эсвэл**
  - Орон гэргүй хүмүүст зориулсан орогнох байр руу нүүх шаардлагатай болох **эсвэл**
  - Ойролцоо амьдарч буй бусад айл руу нүүх
- Гарын үсэг зурсаныхаа дараа би дараах зүйлсийг ойлгож байгаа болно:
  - Байрны эзэнтэйгээ тохиролцоноос бусад тохиолдолд би түрээсийн гэрээнийхээ дагуу төлөх ёстой түрээс, төлөгдөөгүй байгаа түрээс, аливаа хураамж, торгууль эсвэл хүүгээ төлөх үүрэгтэй хэвээр байх болно.
  - Би түрээсийн гэрээнийхээ нөхцлийг дагаж мөрдөх үүрэгтэй хэвээр байх болно.
  - Байрны эзэнтэйгээ тохиролцоноос бусад тохиолдолд би төлөх ёстой төлбөрөө төлж чадаагүй тохиолдолд албадан нүүлгэлтийг түр хугацаанд зогсоох энэхүү тушаал хүчингүй болох үед намайг албадан нүүлгэж болно.
  - Түрээсээ эсвэл орон сууцны төлбөрөө төлөөгүйгээс өөр бусад шалтгаанаар намайг албадан нүүлгэх боломжтой.

**Түрээслэгчдэд зориулсан асуудал шийдвэрлэх хэрэгслүүд**

**Түрээсийн талаарх санхүүгийн яаралтай тусламж авах**  
HUD-зөвшөөрөлтэй орон нутгийн орон сууцны зөвлөгчдийн жагсаалтыг авахаар (800) 569-4287 дугаарт залгах

**Өр цуглуулах талаар асуудлыг мэдээлэх**  
Хэрэглэгчийн Санхүүгийн Хамгаалалтын Товчоонд (CFPB) гомдол илгээх [cfpb.gov/complaint](https://cfpb.gov/complaint)

**Би худал мэдүүлэг өгсөн тохиолдолд шийтгэл хүлээхээ ухамсарлаж, энэхүү мэдүүлэгт <sup>4</sup> гарын үсэг зурсан болно. Энэ нь би дээрх мэдэгдлүүд үнэн бөгөөд худал хэлсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээх болохоо ойлгож буйгаа амлаж байна гэсэн үг юм.**

Та энд гарын үсэг зурна:

**X** \_\_\_\_\_

Огноо: \_\_\_\_\_

## 3. Энэхүү гарын үсэг зурсан хуудсыг танд орон сууц түрээслүүлж буй хувь хүн эсвэл компанид өгнө үү.

**БАЙРНЫ ЭЗДИЙН АНХААРАЛД:** Хууль журмыг дагаж мөрдөж буй танд баярлалаа. Хэрэв та CDC-ийн албадан нүүлгэлтийн талаарх Тушаалыг зөрчвөл та болон/эсвэл таны бизнес торгууль болон шоронд хоригдох зэргийг багтаасан эрүүгийн хариуцлага хүлээхэд хүрч болзошгүй.

<sup>2</sup> COVID-19-ийн Тархалтыг Мужаар Харуулсаныг Харах: <https://covid.cdc.gov/covid-data-tracker/#county-view/>

<sup>3</sup> Орон нутгийн мэргэжилтэн руу залгах нь авах боломжтой бүх тусламжийг олж мэдэх шилдэг арга юм. Орон Сууц, Хот Төлөвлөлтийн Хэлтсээс (HUD) зөвшөөрөлтэй орон нутгийн орон сууцны зөвлөгчдийн жагсаалтыг авахын тулд (800) 569-4287 дугаарт залгаарай.

<sup>4</sup> Хэрэв та албадан нүүлгэлтийг түр хойшлуулах мэдүүлэгт аль хэдийнэ гарын үсэг зурсан бол өөр мэдүүлэг илгээх шаардлагагүй.